

Аудитын код: САГ-2018/12/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: “Лайэн Аудит” ХХК
Аудитор Г.Дэлгэрцэцэг
Утас: 70126778 Цахим хаяг: lionaudit@yahoo.com

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт.....	2
2.6	Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	3
2.9.1	Эздийн өмчийн бусад хэсгийн талаар.....	3
2.9.2	Зорилтот түвшингээс хэтэрсэн зардлын талаар	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	4
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	4
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
3	Менежментийн захидал.....	6
3.1	Эздийн өмчийн бусад хэсгийн талаар.....	7
3.2	Зорилтот түвшингээс хэтэрсэн зардлынталаар.....	8
3.3	Бусад авлагын талаар.....	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлынтайлан.....	10
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүйтайлан	11
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ Б.БАЛДОРЖ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Диспетчерийн Үндэсний төв ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн захирал Б.Балдоржтанд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн эздийн өмчийн бусад хэсгийг зөв тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх, зорилтот түвшингээс хэтэрсэн зардал, бусад авлагын талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн удирдлага санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 14-нөөс 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн. Үүнийг Пайон аудит ХХК-ийн аудитор Г.Дэлгэрцэцэг, аудиторын туслах Ү.Цэнджав нар хариуцаж хэрэгжүүлэв.



Диспетчерийн Үндэсний төв ХХК нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа захирлын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар албан бичгээр Лайэн аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн үндсэн зорилго нь “Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний найдвартай, тогтвортой ажиллагааг хангасан, эдийн засгийн хэмнэлттэй, оновчтой горимыг тооцон мөрдүүлж, хэрэглэгчдийн стандартын шаардлагад нийцсэн цахилгаан, дулаанаар хангах үйл явцыг хоногийн 24 цагийн турш тасралтгүй хянаж зохицуулах, цахилгаан, дулааны үйлдвэрлэлт, хэрэглээний тэнцвэржилтийг хангах” юм.

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 45 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Диспетчерийн Үндэсний төв ХХК нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “unicus” програм ашиглаж бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.



Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын нэгжгүй ч дотоод аудиторыг ажиллуулж байна.

2.6 Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга

Диспетчерийн Үндэсний төв ХХК нь 2017 онд үндсэн үйл ажиллагааны орлого 619,526.8 сая, хүүний орлого 125.8 сая бусад орлого 1,076.0 сая нийт 620,728.6 сая төгрөгийн орлого олж үндсэн үйл ажиллагааны зардалд 616,752.9 сая, бусад зардалд 3,237.6 сая, гадаад валютын ханшийн зөрүүний гарз 64.2 сая бусад алдагдалд 350.2 сая төгрөг зарцуулж, орлогын татварын зардалд 288.9 төгрөг ногдуулж, 34.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад: Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn сайтад хуульд заасан мэдээллийг байршуулсан ба зорилтот түвшингийн төлөвлөгөө гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалтын мэдээллийг байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 45 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Эздийн өмчийн бусад хэсгийн талаар

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,125.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө олж эзэмшсэнийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 1 дүгээр хавсралтын 2 дугаар бүлэгт Эздийн өмчийн бусад хэсэгт “бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзын дүнг толилуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх, цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх;



2.9.2 Зорилтот түвшингээс хэтэрсэн зардлын талаар

Зорилтот түвшинд батлагдсан диспетчерийн зохицуулалтын зардал нийт дүнгээрээ төлөвлөгөөнөөс хэтрээгүй боловч ашиглалтын зардлыг төлөвлөгөөнөөс 10.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталж өгсөн зорилтот түвшингийн хүрээнд зардал гаргах талаар зөвлөмж хүргүүлэх.

Өмгөөлөгч Г.Ганбадрахаас авах 2.0 сая төгрөгийг шүүхээс Г.Ганбадрахаар төлүүлэхгүйгээр шийдвэрлэсэн байхад авлагын үлдэгдлээр бүртгэсэн байна.

Энэ нь тус байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, барагдахгүй авлагыг холбогдох дээд шатны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөц байгуулж хаах талаар зөвлөмж хүргүүлэх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц чухал асуудал: Эрчим хүчний салбарын “Нэг худалдан авагчтай арилжааны загвар” дээрх дансны авлага, экспорт импортын авлага, дансны өглөг зэрэг нь оны эхний дүнгээс өссөн үзүүлэлттэй байгаа, тус загвар дээр үүсч буй хуваарилагдаагүй хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр НББОУС-37 дагуу нөөц үүсгэсэн ч нөөцийг бүрдүүлэх, зарцуулах журам эцэслэн гараагүй, нөөцөөс татвар суутгах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ


Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,138.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 3 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 6 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлын аудитын өлөн улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож



Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 620,728.6 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 6,207.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Диспетчерийн Үндэсний төв ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Эздийн өмчийн бусад хэсгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,125.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө олж эзэмшснийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 1 дүгээр хавсралтын 2 дугаар бүлэгт Эздийн өмчийн бусад хэсэгт “бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзындүнг толилуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

- Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөж ажиллах,
- Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага, ажилтанд



3.2 Зорилтот түвшингээс хэтэрсэн зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Диспетчерийн зохицуулалтын зардал нийт дүнгээрээ төлөвлөгөөнөөс хэтрээгүй боловч ашиглалтын зардлыг төлөвлөгөөнөөс 10.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталж өгсөн зорилтот түвшингийн хүрээнд зардал гаргах талаар зөвлөмж хүргүүлэх.

Эрсдэлүүд

Зардлыг зорилтот түвшингээс хэтрүүлэх.

ҮАГ-ын зөвлөмж

Зардлыг зорилтот түвшингээс хэтрүүлэхгүй байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага, ажилтанд



3.3 БУСАД АВЛАГЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Өмгөөлөгч Г.Ганбадрахаас авах 2.0 сая төгрөгийг шүүхээс Г.Ганбадрахаар төлүүлэхгүйгээр шийдвэрлэсэн байхад авлагын үлдэгдлээр бүртгэсэн байна.

Энэ нь тус байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийн 02 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг зөрчиж байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах,
- Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах,
- Барагдахгүй авлагыг холбогдох дээд шатны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөц байгуулж хаах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31	2017.12.31
ХӨРӨНГӨ		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3 226 981 909,87	3 904 247 851,23
Дансны авлага	25 710 707 093,21	30 833 712 859,13
Татвар, НДШ-ийн авлага	774 275 347,54	678 553 530,53
Бусад авлага	22 728 230,00	2 568 557,82
Бараа материал	284 070 408,63	264 112 404,39
Урьдчилж төлсөн зардал тооцоо	281 964 368,89	42 886 092,00
Эргэлтийн хөрөнгийн дүн	30 300 727 358,14	35 726 081 295,10
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8 878 702 316,90	9 065 643 789,96
Биет бус хөрөнгө	4 031 107 902,98	4 101 386 858,28
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12 909 810 219,88	13 167 030 648,24
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	43 210 537 578,02	48 893 111 943,34
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Богино хугацаатай өр		
Дансны өглөг	17 646 336 501,81	18 882 128 576,56
Татварын өр	1 014 821 043,55	877 675 578,23
НДШ-ийн өглөг	946 060,53	1 788 005,52
Нөөц /өр төлбөр/		3 208 929 421,93
Бусад богино хугацаат өр төлбөр	3 051 525 760,75	4 591 914 605,10
Богино хугацаат өр төлбөрийн дүн	21 713 629 366,64	27 562 436 187,34
Урт хугацаат өр		
Урт хугацаат зээл	9 499 281 707,77	9 197 761 635,45
Бусад урт хугацаат өр төлбөр	3 477 989 465,32	1 856 843 108,13
Урт хугацаат өр төлбөрийн дүн	12 977 271 173,09	11 054 604 743,58
Нийт өр төлбөр	34 690 900 539,73	38 617 040 930,92
Эздийн өмч		
Эзний өмч	1 842 324 959,90	1 842 324 959,90
Нэмж төлөгдсөн капитал	3 406 082,55	
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		1 125 780 613,55
Хуримтлагдсан ашиг	6 673 905 994,84	7 307 965 438,97
Эздийн өмчийн дүн	8 519 637 037,29	10 276 071 012,42
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	43 210 537 577,02	48 893 111 943,34



4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31	/төгрөгөөр/ 2017.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	460 365 234 242,78	619 526 834 867,58
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	449 758 742 877,75	615 583 922 543,66
Нийт ашиг	10 606 491 365,03	3 942 912 323,92
Түрээсийн орлого		
Хүүний орлого	102 838 554,76	125 771 517,27
Бусад орлого	268 446 789,10	1 075 959 432,98
Борлуулалт маркетингийн зардал	1 842 730,51	344 791 532,76
Ерөнхий ба удирдлагын зардал	2 123 338 879,84	700 663 509,06
Санхүүгийн зардал		123 509 506,78
Бусад зардал	4 864 577 409,60	3 237 567 421,93
Гадаад валютын ханшийн зөрүүний олз, (гарз)	(102 655 099,83)	(64 243 825,30)
Бусад ашиг (алдагдал)		(350 188 661,96)
Татварын өмнөх ашиг	3 885 362 589,11	323 678 816,38
Татварын зардал	546 036 087,51	288 963 770,13
Цэвэр ашиг	3 339 326 501,60	34 715 046,25



4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Бүгд
2015 оны 12 сарын 31 ны өдөр	1 842 324 959,90	3 406 082,55		3 334 579 493,24	5 180 310 535,69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				3 339 326 501,60	3 339 326 501,60
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2016 оны 12 сарын 31 ны өдөр	1 842 324 959,90	3 406 082,55		6 673 905 994,84	8 519 637 037,29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(3 406 082,55)	3 406 082,55	599 344 397,88	599 344 397,88
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1 122 374 531,00	34 715 046,25	1 157 089 577,25
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2017 оны 12 сарын 31 ны өдөр	1 842 324 959,90	-	1 125 780 613,55	7 307 965 438,97	10 276 071 012,42



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31	2017.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	515 740 855 376,77	578 684 483 537,35
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	515 740 405 975,77	578 003 136 401,41
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		10 868 577,00
Бусад мөнгөн орлого	449 401,00	670 478 558,94
Мөнгөн зарлагын дүн	512 721 085 149,08	576 565 320 407,25
Ажиллагчдад төлсөн	1 284 158 392,00	2 135 170 797,95
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	98 640 494,42	473 625 383,81
Бараа материал худалдан авахад төлсөн	505 616 331 701,56	563 697 386 766,19
Ашиглалтын зардалд төлсөн	39 395 660,60	44 804 480,88
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28 767 065,59	49 490 545,00
Хүүний төлбөрт төлсөн	63 733 478,87	123 509 506,78
Татварын байгууллагад төлсөн	5 404 848 311,89	9 118 722 362,93
Даатгалын төлбөрт төлсөн	19 431 012,00	3 719 958,00
Бусад мөнгөн зарлага	165 779 032,15	918 890 605,71
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3 019 770 227,69	2 119 163 130,10
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	102 838 554,76	125 771 517,27
Хүлээн авсан хүүний орлого	102 838 554,76	125 771 517,27
Мөнгөн зарлагын дүн	-	1 215 086 060,15
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1 019 190 762,45
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		195 895 297,70
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	102 838 554,76	(1 089 314 542,88)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	116 938 033,43	8 933 230,48
Бусад	116 938 033,43	8 933 230,48
Мөнгөн зарлагын дүн	308 572 593,07	361 515 876,22
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	301 520 073,07	301 520 073,32
Төлсөн ноогдол ашиг	7 052 520,00	
Бусад		59 995 802,90
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(191 634 559,64)	(352 582 645,74)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2 930 974 222,81	677 265 941,48
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	296 547 088,06	3 226 981 909,87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3 226 981 909,87	3 904 247 851,23

